



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН МАТЕРИАЛ

2024

АГЛУЛГА

Хурлын зар

Хурлаар хэлэлцэх асуудал

Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт

Ээлжит хурал хуралдуулах шийдвэр

Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг

Хурлаар хэлэлцэх асуудлуудтай холбоотой материал

- Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн аудитаар баталгаажсан дүгнэлтийг тайлагнах
- ТУЗ-ийн 2024 оны төсөв батлах
- ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолын төслүүд

Саналын хуудасны загвар

Тэмдэглэл

“БиДиСЕК ҮЦК” ХК-ийн хувьцаа ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“БиДиСЕК” ҮЦК ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 04 сарын 02 - ны өдөр 10:00 цагт <http://agm.mn/> холбоосоор дамжуулан цахим хэлбэрээр зохион байгуулагдана.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдөр: 2024 оны 03 сарын 11
Цахим хурал зохион байгуулах холбоос: <https://agm.mn/>

ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛУУД:

- Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн аудитаар баталгаажсан дүгнэлтийг тайлагнах
- Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг танилцуулах
- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны төсөв батлах
- Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох

Хурлаар хэлэлцэх асуудал, түүнтэй холбогдох баримт бичгийг 2024 оны 2 дугаар сарын 26-ны өдрөөс 2024 оны 04 -р сарын 01-ний өдөр хүртэл ажлын өдрүүдэд 09⁰⁰-18⁰⁰ цагийн хооронд “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн байранд ирж танилцах, эсвэл харьяалагдах Үнэт Цаасны Компаниас авч танилцах боломжтой.

Хуралд оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчид саналаа бүртгэлтэй брокер, дилерийн компаниар дамжуулах, компанийн байранд биеэр ирж цаасаар өгөх боломжтой. Урьдчилан санал авах сүүлчийн хугацааг 2024 оны 04 сарын 01-ний өдрөөр тасалбар болгоно.

Хурлын талаар дэлгэрэнгүй мэдээллийг хурал зохион байгуулах комиссын утсаар холбогдон авна уу.

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Залуучуудын Өргөн Чөлөө 27/1
“БиДиСЕК ҮЦК” ХК-ийн байр

Утас: 75551919, 80498649

Электрон шуудангийн хаяг: info@bdsec.mn, enkhjin@bdsec.mn

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

- 1 Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн аудитаар баталгаажсан дүгнэлтийг тайлагнах
- 2 ТУЗ-ийн 2024 оны төсөв батлах
- 3 ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАЖ БОЛОХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

- 1 Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан
- 2 ТУЗ-д нэр дэвшигчдийн танилцуулга
- 3 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материал

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ШИЙДВЭР



“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 02 сарын 19-ны өдөр

№ 051/24

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.2 дахь заалт, Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 02 сарын 19-ний өдрийн санал хураалтын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

- “БидиСек ҮЦК” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04 сарын 02-ны өдөр 10 цагт <http://agm.bdsec.mn/> холбоосоор дамжуулан цахим хэлбэрээр хуралдуулсугай.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
 - Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн аудитаар баталгаажсан дүгнэлтийг тайлагнах
 - Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг танилцуулах
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны төсөв батлах
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрөөр тогтоосугай.
- Ээлжит хурлыг хуралдуулахтай холбогдуулан хурлын зарыг 0.1 дүгээр хавсралтаар батлан оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг хүргэхээр 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдөр өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгээр болон компани хөрөнгийн биржийн цахим хуудсаар мэдээлэх. Энэ мэдээллийг анх зар хүргэсэн өдрөөс

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ШИЙДВЭР

хойш 15 хоногийн дараа буюу 2024 оны 03 дугаар сарын 07–ны өдөр дахин зар гаргахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

5. Ээлжит хурлыг хуралдуулахтай холбогдуулан хурлын дэгийг 02 дугаар хавсралтаар, хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь энэхүү шийдвэрийн 03 дугаар хавсралтад заасан бичиг баримттай 2024 оны 2 дугаар сарын 26-ны өдрөөс 2024 оны 04-р сарын 01-ний өдөр хүртэл ажлын өдрүүдэд 09⁰⁰-18⁰⁰ цагийн хооронд "БиДиСЕК ҮЦК" ХК-ийн байранд ирж танилцах, эсвэл харьяалагдах Үнэт Цаасны Компаниас авч танилцах эрхтэй болохыг дурдсугай.
6. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах "Саналын хуудас"-ын агуулгыг 04 дугаар хавсралтаар баталсугай.
7. Урьдчилан санал өгөх хувьцаа эзэмшигчээс "Санал авах хуудас"-ыг хүлээн авах сүүлийн өдрийг харьяалагдах үнэт цаасны компаниар нь дамжуулан хурал хуралдах өдрөөс ажлын 1 хоногийн өмнө, Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчээс хурал зохион байгуулагдах өдөр санал хүлээн авахаар тогтсугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссын даргаар Харилцагчийн албаны захирал Б.Онон, гишүүдээр Б.Мягмарсайхан, Э.Пүрэвжаргал, М.Баяр-Өлзий нарыг тус тус томилсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын даргаар Д.Даянбилгүүн, тооллогын комиссын даргаар Э.Мөнхсүвд, гишүүдээр М.Мишээл, Ө.Халиун нарыг тус тус томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



/Д.ДАЯНБИЛГҮҮН/

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДЭГ

1. Хурлын ирц бүртгэл

1.1. Хурлын ирцийг бүртгэх (ажлын хэсэг) 09:50-10:00

1.2. Хурлын ирцийг мэдээлэх (ажлын хэсэг) 10:00-10:05

2. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хурлын дарга нээх 10:05-10:15

3. Хэлэлцэх асуудлуудыг төлөвлөгөөний дагуу танилцуулах

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн аудитаар баталгаажсан дүгнэлтийг тайлагнах 10:15-10:30

2. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах 10:30-10:40

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны төсөв батлах 10:40-11:50

4. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох 11:50-11:00

4. Хэлэлцэж буй асуудлуудтай холбоотой асуулт хариулт 11:00-11:10

5. Саналын хуудсыг бөглөх, санал хураалт 11:10-11:20

6. Хурлын завсарлага 11:20-11:30

7. Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах, батлуулах 11:30-11:40

8. Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах 11:40-11:50

9. Хурлыг хаах (хурлын дарга) 5 минут

2023

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

Mongolian Re

2023.03.31

“Үндэсний давхар
даатгал”

IPO

хийх зөвшөөрөл



Улаанбаатар

2023.10.02-10.04

“УЛААНБААТАР ХОТ”

БОНД

нийтэд санал болгох зөвшөөрөл



ХААН БАНК

2023.12.11

“ХААН Банк” ХК
НОГООН БОНД



2023.03.27

“Мөнхийн үсэг” ХХК
Хаалттай бонд



ХААН БАНК

2023.04.13-04.19

“ХААН Банк” ХК
IPO



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ ХОРОО



МОНГОЛЫН
ХӨРӨНГӨ БИРЖ

2023.10.25 2023.11.27

Уул уурхайн бүтээгдэхүүний
биржийн арилжааны зуучлагч
(брокер)-ийн үйл ажиллагаа
эрхлэх тусгай зөвшөөрөл

АНДЕРРАЙТЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

“БиДиСЕК ҮЦК” ХК нь Монгол Улсын эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулахуйц компаниудын бизнесийг өргөжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг татан төвлөрүүлэхэд хамтран ажиллаж байна. Компаниудын онцлог, үйл ажиллагаанаас хамааран түүнд тохирсон санхүүжилтийн хувилбарыг боловсруулан биржийн болон биржийн бус зах зээлээс хөрөнгө татан төвлөрүүлэхэд андеррайтераар ажиллаж, энэ чиглэлээр ихээхэн туршлага хуримтлуулсан.



Судалсан төсөл салбараар



АНДЕРРАЙТЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА




Нийтэд хувьцаагаа анх удаа санал болгох ажиллагаа - IPO

183.4
тэрбум төгрөг



Монгол Улсын анхны ногоон бондын хөтөлбөр – I үе шат

17.0
тэрбум төгрөг



Монгол Улсын анхны орон нутгийн бондыг нийтэд санал болгох зөвшөөрлийг авав.

500.0
тэрбум төгрөг хүртэл



Mongolian Re

Хорооноос IPO хийх зөвшөөрөл авав.

11.5
тэрбум төгрөг

БРОКЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

"Монголын Хөрөнгийн Бирж" ХК-ийн нийт арилжаанд оролцогч компаниудын арилжааны мэдээлэл




2023 оны
"БиДиСЕК ҮЦК" ХК-ийн
нийт арилжааны дүн:

389.2
тэрбум төгрөг

МХБ дээр нийт 1.45 их наяд төгрөгийн арилжаа хийгдсэний 26.8% буюу 389.2 тэрбум төгрөгийн арилжааг "БиДиСЕК ҮЦК" ХК гүйцэтгэсэн байна.

БРОКЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

“БиДиСЕК ҮЦК”-ийн 2023 оны нийт арилжааны бүтэц



Үнэт цаасны данс

НИЙТ ОНЛАЙН
ХАРИЛЦАГЧ

9,592



Нийт арилжаанд оролцсон харилцагчдын тоо

12,710



Онлайнаар арилжаанд оролцсон харилцагчдын тоо

2,141

Онлайнаар ирүүлсэн захиалгын тоо

18,024

Онлайнаар авсан захиалгын дүн

15.88 тэрбум ₮

БРОКЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тусгай зөвшөөрөл болон гишүүнчлэл



“БиДиСЕК ҮЦК” ХК

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагч (брокер)-ийн үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрөв.




Санхүүгийн Зохицуулах Хороо

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагч (брокер)-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгов.




Монголын Хөрөнгийн Бирж

Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах зуучлагч (брокер)-ийн гишүүнчлэл олгов.



2023.10.25-ны өдөр Тусгай зөвшөөрөл олгов.
Санхүүгийн Зохицуулах Хороо



2023.11.27-ны өдөр гишүүнээр элсүүлэв.
Монголын Хөрөнгийн Бирж

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

Зөвлөгөө өгөх ажлын хүрээнд

1. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар санал авах ажиллагааны онцлог, зохион байгуулалтад анхаарах зүйлсийн талаар зөвлөмж өгөх
2. Хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулах тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр тараах зарын загварыг боловсруулахад оролцох
3. Санал өгөх зааварчилгааг бэлтгэх
4. Хувьцаа эзэмшигчдийн хураалтаар гаргах тогтоол шийдвэрийн төслийг боловсруулахад оролцох
5. Хувьцаа эзэмшигчдийн хуралттай холбоотойгоор хувьцаа эзэмшигчдээс ирсэн асуулт тодруулгуудад хариулахад идэвхтэй оролцох

ЭЭЛЖИТ :



"БидиСЕК ҮЦК" ХК



"АРУ" ХК



"Богд Банк" ХК



"Бодь даатгал" ХК



"Говийн өндөр" ХК



"Баянтээг" ХК



"Э-Транс
логистикс" ХК



"Эрдэнэ Ресурс
Девелопмент" ХК

ЭЭЛЖИТ БУС:



"ХААН Банк" ХК



"Мөнх жим" ХК

2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

/Мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,660,936.4	2,898,220.7
Бусад авлага	4,130,293.3	3,268,385.4
Санхүүгийн хөрөнгө	26,172,741.3	34,042,464.9
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	133,059.2	443,961.6
Эргэлтийн хөрөнгийн дүн	33,097,030.2	40,653,032.7
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	4,381,510.3	4,286,593.1
Биет бус хөрөнгө	40,864.3	36,671.7
Урт хугацаат хөрөнгө оруулалт	51,000.0	51,000.0
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,473,374.6	4,374,264.8
Нийт хөрөнгийн дүн	37,570,404.8	45,027,297.4
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
ӨР ТӨЛБӨР		
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
Дансны өглөг	1,156,799.4	1,567,061.2
Цалингийн өглөг	40,409.2	68,449.7
Татварын өр	25,441.4	66,980.1
НДШ - ийн өглөг	24,438.1	33,769.8
Богино хугацаат зээл	999,831.7	0.00
Хүүний өглөг	377,938.5	2,598.0
Урьдчилж орсон орлого	477.9	477.9
Нөөц /өр төлбөр/	41,084.6	41,084.6
Бусад богино хугацаат өр төлбөр	168,584.9	615,306.7
Борлуулах зорилгоор эзэмшиж буй бүлэг хөрөнгөнд хамаарах өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,835,005.7	2,395,728.0
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
Урт хугацаат зээл	20,592,499.7	27,327,536.4
Урт хугацаат өр төлбөрийн дүн	20,592,499.7	27,327,536.4
Өр төлбөрийн нийт дүн	23,427,505.4	29,723,264.4
ЭЗДИЙН ӨМЧ		
Эздийн өмч		
Өмч -төрийн		
-хувийн	1,369,488.3	9,326,763.1
-хувьцаат	0.0	0.0
Халаасны хувьцаа	0.0	0.0
Нэмж төлөгдсөн капитал	7,957,309.3	34.5
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,824,524.4	3,824,524.4
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.0	0.0
Эздийн өмчийн бусад хэсэг	-600,193.9	0.0
Хуримтлагдсан ашиг	1,591,771.3	2,152,711.1
Эздийн өмчийн дүн	14,142,899.4	15,304,033.1
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	37,570,404.8	45,027,297.4

2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

/Мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Үйл ажиллагааны орлого	2,447,245.8	4,873,387.3
Брокер, дилерийн үйл ажиллагааны орлого	209,782.7	1,761,750.7
Андеррайтерийн үйл ажиллагааны орлого	1,844,881.1	825,366.2
Үнэт цаасны арилжааны цэвэр орлого	392,582.0	2,286,270.4
Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн цэвэр орлого	0.0	0.0
Түрээсийн орлого	160,147.4	197,470.6
Хүүний орлого	544,518.0	1,460,648.3
Ногдол ашгийн орлого	149,583.7	109,711.7
Хувьцааны ногдол ашиг	149,583.7	109,711.7
Хараат болон хамтарсан компаниас олсон ашиг	0.0	0.0
Эрхийн шимтгэлийн орлого	0.0	0.0
Бусад орлого	162,247.7	169,710.9
Борлуулалт, маркетингийн зардал	0.0	2,618,938.9
Ерөнхий ба удирдлагын зардал	2,430,353.5	1,583,833.3
Санхүүгийн зардал	1,162,235.7	2,040,641.9
Бусад зардал	1,800.0	11,598.5
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-3,229,522.8	730,339.2
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	15,812.5	0.0
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.0	0.0
Бусад ашиг (алдагдал)	0.0	0.0
Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	-3,344,356.9	1,286,255.6
Орлогын татварын зардал	151.8	125,121.9
Татварын дараах ашиг (алдагдал)	-3,344,508.7	1,161,133.7
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	0.0	0.0
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-3,344,508.7	1,161,133.7

КОМПАНИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙГДСЭН ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТ

“БиДиСЕК ҮЦК” ХК нь 2023 онд Монголын Хөрөнгийн Биржийн нийт арилжааны 26.8 хувь буюу 389.2 тэрбум төгрөгийн арилжааг дангаараа гүйцэтгэлээ.

Компани нь 2023 онд биржийн бус зах зээл дээр “Мөнхийн үсэг” ХХК-ийн хаалттай бондын ажиллагаанд андеррайтераар ажиллан 3 тэрбум төгрөгийг татан төвлөрүүллээ.

Банкны тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр банкны системийн нөлөө бүхий банкууд нээлттэй хувьцаат компани хэлбэрт шилжихийг үүрэг болгосон. Үүний хүрээнд “БиДиСЕК ҮЦК” ХК нь Монгол Улсын хамгийн их харилцагчтай, санхүүгийн хүчирхэг үзүүлэлттэй, банкны системийн нөлөө бүхий хамгийн том банк болох “ХААН Банк” ХК-ийн хувьцааг анх удаа олон нийтэд санал болгох ажиллагаанд тэргүүлэх андеррайтераар сонгогдон ажиллаж нийт 29,345 хөрөнгө оруулагчаас 336 тэрбум төгрөгийн захиалга ирснээр анхдагч зах зээлийн захиалга 100 хувь амжилттай зохион байгууллаа.

Мөн компани нь Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагч (брокер)-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Санхүүгийн Зохицуулах Хорооноос амжилттай аван Монголын Хөрөнгийн биржийн гишүүнээр элсэн уур уурхайн биржийн арилжааны зуучлагч (брокер)-ийн үйл ажиллагаа явуулахад бэлэн боллоо.

Монгол Улсын анхны ногоон бонд гаргах үйл ажиллагаанд андеррайтераар ажиллаж эхний шат болох 17 тэрбум төгрөг буюу 5 сая ам.доллартой тэнцэх хөрөнгийг амжилттай татан төвлөрүүллээ.

“БиДиСЕК ҮЦК” ХК нь 2023 онд 6.81 тэрбум төгрөгийн нийт орлого, 1.16 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, хувьцаа эзэмшигчдээ нэгж хувьцаанд 33.91 төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн.

Иймд “БиДиСЕК ҮЦК” ХК нь 2023 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг хангалттай хэмээн Төлөөлөн Удирдах Зөвлөл дүгнэлээ.

ТУЗ-ИЙН 2024 ОНЫ ТӨСӨВ БАТЛАХ

	Гишүүний сарын цалин /төгрөг/	Нийт гишүүний сарын цалин /ТУЗ-9 гишүүн, НБД-1/	Жилийн цалин /төгрөг/
ТУЗ-ийн гишүүдийн цалин	600,000	5,400,000	64,800,000
ТУЗ-ийн НБД-ын цалин	500,000		6,000,000
ТУЗ-ын хурлын зардал /бичиг цаас, ус, зэрэг/	1,500,000	Улиралд 1 удаа /жилд 4 удаа/	6,000,000
Нийт			76,800,000

ТУЗ-ИЙН ЕРДИЙН БОЛОН ХАРААТ БУС ГИШҮҮДИЙГ СОНГОХ

ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧ



1. Ерөнхий мэдээлэл

Овог нэр:	Данзан Даянбилгүүн
Иргэний харьяалал:	Монгол
Төрсөн он сар:	1976 оны 06 сарын 10

2. Боловсролын талаар

Санхүү Эдийн Засгийн Их Сургууль, Бизнесийн удирдлага, Магистрт	2003-2005
Европ хэлний дээд сургууль	1994-1998

3. Ажлын туршлага

“БиДиСЕК ҮЦК” ХК-ийн Ерөнхийлөгч	2022 оны 11 сараас
“БиДиСЕК ҮЦК” ХК-ийн Гүйцэтгэх захирал	1999-2022.11
“БиДиСЕК ҮЦК” ХК-ийн салбарын менежер	1997-1999
Улсын Их Хурлын Тамгын газрын гишүүний орон тооны ажилтан	1995-1997
Эдийн Тэнгэр Банк – Оператор, нягтлан бодогч	1994-1995
“Юнизо” ХХК менежер	1993-1994

ТУЗ-ИЙН ЕРДИЙН БОЛОН ХАРААТ БУС ГИШҮҮДИЙГ СОНГОХ

ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧ



1. Ерөнхий мэдээлэл

Овог нэр:	Бүрэнмэнд Лхагвадорж
Иргэний харьяалал:	Монгол
Төрсөн он сар:	1976 оны 02 сарын 04

2. Боловсролын талаар

Монгол улсын их сургууль Нефтийн инженер	1993-1997
---	-----------

3. Ажлын туршлага

"БиДиСЕК ҮЦК" ХК-ийн Гүйцэтгэх захирал	2022 оны 11 сараас
"БиДиСЕК ҮЦК" ХК-ийн Тэргүүн дэд захирал	1999-2022.11 сар

ТУЗ-ИЙН ЕРДИЙН БОЛОН ХАРААТ БУС ГИШҮҮДИЙГ СОНГОХ

ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧ



1. Ерөнхий мэдээлэл

Овог нэр:	Нарангэрэл Батгэрэл
Иргэний харьяалал:	Монгол
Төрсөн он сар:	1974 оны 12 сарын 22

2. Боловсролын талаар

Монгол улсын их сургуулийн харъяа ОУХДС	1995-1999
Олон улсын харилцааны мэргэжилтэн, Бакалавр	

3. Ажлын туршлага

“БиДиСЕК ҮЦК” ХК-ийн Тэргүүн дэд захирал	2022 оны 11 сараас
“БиДиСЕК ҮЦК” ХК-ийн Дэд захирал	2007-2022.11 сар
“БиДиСЕК ҮЦК” ХК-ийн олон нийттэй харилцах албаны менежер	2005-2007

ТУЗ-ИЙН ЕРДИЙН БОЛОН ХАРААТ БУС ГИШҮҮДИЙГ СОНГОХ

ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧ



1. Ерөнхий мэдээлэл

Овог нэр:	Uluc Bingol
Иргэний харьяалал:	Турк
Төрсөн он сар:	1986 оны 08 сарын 27

2. Боловсролын талаар

London Business School MSc in Finance	2011-2012
Кос Их Сургууль, Турк BSc in Industrial Engineering	2004-2008

3. Ажлын туршлага

Импера Капитал, Турк Дэд захирал	2012 оноос одоог хүртэл
Garanti Bank, Турк Эрсдэлийн ахлах шинжээч	2008-2011

ТУЗ-ИЙН ЕРДИЙН БОЛОН ХАРААТ БУС ГИШҮҮДИЙГ СОНГОХ

ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧ



1. Ерөнхий мэдээлэл

Овог нэр:	Одгийв Уранбайгал
Иргэний харьяалал:	Монгол
Төрсөн он сар:	1985 оны 05 сарын 28

2. Боловсролын талаар

Санхүү эдийн засгийн их сургууль Санхүүгийн удирдлага, Магистр	2012-2016
Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургууль Бизнесийн удирдлага, Бакалавр	2008-2011

3. Ажлын туршлага

“БиДиСЕК ҮЦК” ХК-ийн Back Office албаны захирал	2022 оноос хойш
“БиДиСЕК ҮЦК” ХК-ийн харилцагчийн албаны менежер	2016-2022
“БиДиСЕК ҮЦК” ХК-ийн Back Office албаны менежер	2012-2016
“БиДиСЕК ҮЦК” ХК-ийн харилцагчийн алба, брокер	2009-2012

ТУЗ-ИЙН ЕРДИЙН БОЛОН ХАРААТ БУС ГИШҮҮДИЙГ СОНГОХ

ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧ



1. Ерөнхий мэдээлэл

Овог нэр:	Hitoshi Tani
Иргэний харьяалал:	Япон
Төрсөн он сар:	1954 оны 12 сарын 20

2. Ажлын туршлага

Sanaa EХE Группын
Ерөнхийлөгч

ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧ



1. Ерөнхий мэдээлэл

Овог нэр:	Баттогтох Энхбаяр
Иргэний харьяалал:	Монгол
Төрсөн он сар:	1980 оны 02 сарын 15

2. Боловсролын талаар

Хитоцубашигийн Их Сургууль , Япон Эдийн засаг, Магистр	2004-2006
Хитоцубашигийн Их Сургууль , Япон Эдийн засаг, Бакалавр	2000-2004
Монгол Улсын Их Сургууль Эдийн засаг, Бакалавр	1997-1999

3. Ажлын туршлага

Sanaa EХE ХХК-ийн Гүйцэтгэх захирал	2009 оноос одоог хүртэл
Гадаадын хөрөнгө оруулалттай том оврын Цахилгаан Станцын төсөл, Зөвлөх	2014-2018
Deutsche Bank, Global Markets, Токиогийн хөрөнгийн бирж дээрх хувьцааны багцийн арилжаа хариуцсан трэйдр, дилер	2005-2008

ТУЗ-ИЙН ЕРДИЙН БОЛОН ХАРААТ БУС ГИШҮҮДИЙГ СОНГОХ

ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧ



1. Ерөнхий мэдээлэл

Овог нэр:	Дарамранз Амгаланбаяр
Иргэний харьяалал:	Монгол
Төрсөн он сар:	1975 оны 12 сарын 22

2. Боловсролын талаар

Монгол Улсын Их Сургууль
Эдийн засагч, Бакалавр

3. Ажлын туршлага

МСМ Группийн Захиргааны мэргэжилтэн

ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧ



1. Ерөнхий мэдээлэл

Овог нэр:	Мөнхжаргал Туяа
Иргэний харьяалал:	Монгол
Төрсөн он сар:	1976 оны 07 сарын 28

2. Боловсролын талаар

Жонс Хопкинсийн их сургууль	2019-2023
Санхүү эдийн засгийн их сургууль	2014-2018
Хүний нөөцийн удирдлага, Магистр	
Монгол улсын их сургууль	
Олон улсын харилцаа, Бакалавр	2000-2002

3. Ажлын туршлага

“Шилдэг сургууль”-ийн ТУЗ-ийн дарга	2014-Одоог хүртэл
“EDEX Mongolia”-ийн Гүйцэтгэх захирал, Үүсгэн байгуулагч	2001-Одоог хүртэл
“EDEXMN” ХХК-ийн хувьцаа эзэмшигч	2007-Одоог хүртэл

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААС ГАРАХ ТОГТООЛЫН ТӨСЛҮҮД

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 02-ны өдөр

№ 01/24

Улаанбаатар хот

Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн аудитаар баталгаажсан дүгнэлтийг тайлагнах тухай

Компанийн тухай хуулийн 62.1.9 дэх заалт болон 2024 оны 04 сарын 02-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн
ТОГТООХ НЬ:

- Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан болон аудитлагдсан санхүүгийн тайланг хангалттай гэж үзсүгэй.

ХУРЛЫН ДАРГА:

Д.ДАЯНБИЛГҮҮН

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААС ГАРАХ ТОГТООЛЫН ТӨСЛҮҮД

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 02-ны өдөр

№ 02/24

Улаанбаатар хот

Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62.1.9 дэх заалт болон 2024 оны 04 сарын 02-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн
ТОГТООХ НЬ:

- Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА:

Д.ДАЯНБИЛГҮҮН

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААС ГАРАХ ТОГТООЛЫН ТӨСЛҮҮД

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 02-ны өдөр

№ 03/24

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны төсөв батлах тухай

Компанийн тухай хуулийн 62.1.13 дэх заалт болон 2024 оны 04 сарын 02-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн
ТОГТООХ НЬ:

- Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн төсвийг хавсралтаар нийт 76,800,000 төгрөгөөр баталсугай.
- Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн төсөвт хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн цалин урамшууллын хороонд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА:

Д.ДАЯНБИЛГҮҮН

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААС ГАРАХ ТОГТООЛЫН ТӨСЛҮҮД

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 02-ны өдөр

№ 04/24

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62.1.7. дэх заалт болон 2024 оны 04-р сарын 02-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнд олонхын санал авсан:

Ердийн гишүүдэд:

- Данзан ДАЯНБИЛГҮҮН
- Бүрэнмэнд ЛХАГВАДОРЖ
- Нарангэрэл БАТГЭРЭЛ
- УЛУЧ Бингол

Хараат бус гишүүдэд

- Одгийв УРАНБАЙГАЛ
- ХИТОШИ Тани
- Дарамранз АМГАЛАНБАЯР
- Баяртогтох ЭНХБАЯР
- Мөнхжаргал ТУЯА

нарыг тус тус Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнээр сонгосугай

ХУРЛЫН ДАРГА:

Д.ДАЯНБИЛГҮҮН

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААС ГАРАХ ТОГТООЛЫН ТӨСЛҮҮД

*“БиДиСЕК ҮЦК” ХК-ийн 2024 оны
04 сарын 02-ны өдрийн №03/24 дугаар шийдвэрийн
ХАВСРАЛТ №1*

	Гишүүний сарын цалин /төгрөг/	Нийт гишүүний сарын цалин /ТУЗ-9 гишүүн, НБД-1/	Жилийн цалин /төгрөг/
ТУЗ-ийн гишүүдийн цалин	600,000	5,400,000	64,800,000
ТУЗ-ийн НБД-ын цалин	500,000		6,000,000
ТУЗ-ын хурлын зардал /бичиг цаас, ус, зэрэг/ Нийт	1,500,000	Улиралд 1 удаа /жилд 4 удаа/	6,000,000 76,800,000

САНАЛЫН ХУУДАСНЫ ЗАГВАР

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 05/24 дугаар тогтоолын "Хавсралт №5"

"БидиСЕК ҮЦК" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛААР ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭЭС САНАЛ АВАХ ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн овог нэр.....

Регистрийн дугаар

Хувьцаа эзэмшигчийн бүртгэлийн дугаар

Эзэмшиж буй хувьцааны төрөл тоо

Бүртгэсэн / Брокер дилерийн компани /

"БидиСЕК ҮЦК" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 10 цагт <http://aqm.mn/> холбоосоор дамжуулан цахим хэлбэрээр зохион байгуулагдана.

№	Хэлэлцэх асуудлын нэр	Санал авах арга	Хурлаас гарах шийдвэрийн төсөл	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	Татгалзсан тохиолдолд таны өгөх санал
1.	Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах	Ердийн	Тогтоол №1	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
2.	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны төсөв батлах		Тогтоол №2	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
3.	Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох		Тогтоол №3	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Хурлаар танилцуулах асуудлууд:							
1.	Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн аудитаар баталгаажсан дүгнэлтийг тайлагнах						
2.	Компани ногдол ашиг тараах эсэх талаарх ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах						

Брокер Гарын үсэг

/ тэмдэг /

Хувьцаа Эзэмшигч Гарын үсэг

2024 он сар..... өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон Тооллогын Комиссын дарга

Комиссын Гишүүн

Комиссын Гишүүн

Комиссын Гишүүн

Хүчингүйд тооцсон бол шалтгаан

САНАЛЫН ХУУДАСНЫ ЗАГВАР

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 05/24 дугаар тогтоолын "Хавсралт №5"

"БиДиСЕК ҮЦК" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛААР ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭЭС САНАЛ АВАХ ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн овог нэр.....
Регистрийн дугаар
Хувьцаа эзэмшигчийн бүртгэлийн дугаар
Эзэмшиж буй хувьцааны төрөл тоо
Кумулятив хувьцааны тоо:
Бүртгэсэн / Брокер дилерийн компани /

"БиДиСЕК ҮЦК" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 10 цагт, <http://agm.mn/> холбоосоор дамжуулан цахим хэлбэрээр байгуулагдана.

4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох						
ТУЗ-ийн ердийн гишүүн:		Санал авах арга	Хурлаас гарах шийдвэрийн төсөл	Нэр дэвшигчид өгөх саналын тоо		
1.	Данзан ДАЯНБИЛГҮҮН	Кумулятив	Тогтоол №....			
2.	Бүрэнмэнд ЛХАГВАДОРЖ					
3.	Нарангэрэл БАТГЭРЭЛ					
4.	УЛУЧ Бингол					
5.	Одгийв Уранбайгал					
ТУЗ-ийн хараат бус гишүүн:						Нэр дэвшигчид өгөх саналын тоо
1.	ХИТОШИ Тани					
2.	Баяртогтох ЭНХБАЯР					
3.	Дарамранз АМГАЛАНБАЯР					
4.	Мөнхжаргал ТУЯА					

Брокер Гарын үсэг
/ тэмдэг /

Хувьцаа Эзэмшигч Гарын үсэг
2024 он..... сар.....өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон Тооллогын Комиссын дарга

Комиссын Гишүүн

Комиссын Гишүүн

Комиссын Гишүүн

Хүчингүйд тооцсон бол шалтгаан /

САНАЛЫН ХУУДСЫГ БӨГЛӨХ САНАМЖ

Саналын хуудсыг дараах зааврын дагуу бөглөнө.

1. Саналын ердийн аргаар тоолох асуудалд:

- ▶ Тухайн асуудалд зөвшөөрсөн, татгалзсан, түдгэлзсэн гэсэн аль нэгд нь ✓ эсвэл + тэмдгээр саналаа өгнө.
- ▶ Засварласан, балласан, эсвэл болон аль нэг саналыг бөглөөгүй бол саналын хуудсыг хүчингүйд тооцно.

2. Саналыг кумулятив аргаар тоолох асуудалд:

- ▶ ТУЗ-ийн гишүүдэд санал өгөхдөө кумулятив аргаар санал хураана.
- ▶ Хувьцааны нэгж тутамд ТУЗ-ийн гишүүнийг сонгох 1 саналын эрх байна. Хувьцаа эзэмшигч саналын эрхээ ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшиж буй нэг нэр дэвшигчид бүгдийг, эсхүл хэд хэдэн нэр дэвшигчид хуваан өгөх эрхтэй.
- ▶ Жишээ нь: Хувьцаа эзэмшигч А нэр бүхий ХК-ийн 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг. Тус компанийн дүрмээр ТУЗ нь 9 гишүүнтэй, үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоожээ. Хувьцаа эзэмшигч А-ийн 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй болно.
 - Хувилбар А: Хувьцаа эзэмшигч А нийт 900 саналын эрхээ бүгдийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон нэг нэр дэвшигчид өгч болно.
 - Хувилбар Б: Хувьцаа эзэмшигч А нийт 900 саналын эрхийн 600 эрхээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 эрхээ хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус өгч болно. Хувьцаа эзэмшигч А саналын эрхээ ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамаарна.

Утас: 7555-1919

И-мэйл: info@bdsec.mn

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Залуучуудын Өргөн Чөлөө 27/1
"БиДиСЕК ҮЦК" ХК-ийн байр